



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Шарга сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2024/56/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Алтай хот
2024 он

Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа
Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn
Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг
Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn
Ахлах аудитор: Д.Цэрэнханд
Утас: 99086371 Цахим хаяг: tserenkhandd@audit.gov.mn
Аудитор: Б.Батбаатар
Утас: 89593311 Цахим хаяг: batbaatarb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402. Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.26 № 101

танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Шарга сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дээрх алдаа зөрчлийг эс тооцвол Шарга сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг тасалсан, Засаг даргын нөөц хөрөнгийг бэлэг дурсгал, шагналд зарцуулсан, нийгмийн даатгалын хэлтэст цалин дутуу тайлагнасан, зардлын эдийн засгийн ангилал зөрчсөн цалингийн зардлын төсвөөс нийгмийн даатгалын шимтгэл төлсөн, бараа материалыг орлого авалгүй шууд шаардахаар зарлагдсан зэрэг 27,590.3 мянган төгрөгийн зөрчил нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8, 16 дугаар зүйлийн 16.5.5, 16.5.7, 22 дугаар зүйлийн 22.1, 41 дүгээр зүйлийн 41.12.2, Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.3, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 дахь заалттай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Засаг даргын нөөц хөрөнгийг зарцуулах журмаар шагнал урамшуулал, нэг удаагийн буцалтгүй тусламж, дэмжлэг олгох бүрэн эрхийг Засаг даргад олгосон боловч Төрийн хэмнэлтийн тухай хуулиар дээрх арга хэмжээний зардлыг зарцуулахыг хориглосон байна.

0702900351

Аудитын гол асуудал

Орон нутгийн төсвөөс олгосон санхүүжилт өмнөх оноос 191,588.6 мянган төгрөгөөр өссөн нь төрийн албан хаагчдын цалин, хөлс нэмэгдсэн, тус байгууллага төвлөрсөн халаалтын системд холбогдсонтой тус тус холбоотой байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд 3 хөтөлбөр, 6 зорилт, 103 арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаснаас 72 арга хэмжээг бүрэн, 30 арга хэмжээг 66.7 хувь буюу нийт дүнгээр 91.8 хувиар биелэлтийг хүргүүлсэн бөгөөд Шарга сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас нийт дүнгээр 73.3 хувиар үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Г.ГҮНЖИДМАА



Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

/мян.төгрөгөөр/

	Үзүүлэлт	2022.12.31	2023.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	82,574.1	148,002.4
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,594,076.6	9,660,140.3
	Нийт хөрөнгийн дүн	1,676,650.7	9,808,142.7
	Нийт өр төлбөрийн дүн	-	9,931.0
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,676,650.7	9,798,211.7
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,676,650.7	9,808,142.7
	Үйл ажиллагааны орлогын дүн	1,141,945.6	9,011,208.3
	Үйл ажиллагааны зардлын дүн	559,376.5	878,491.0
	Үйл ажиллагааны үр дүн	582,569.1	8,132,717.2
	Үйл ажиллагааны бус үр дүн	-	11,156.2
	Үйл ажиллагааны нийт үр дүн	582,569.1	8,121,560.9
	Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	1,676,650.7	9,798,211.7
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,094,081.6	1,676,650.7
	Тайлант оны үр дүн	582,569.1	8,121,560.9
	Эцсийн үлдэгдэл	1,676,650.7	9,798,211.7
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	454,435.3	679,981.8
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	460,966.1	675,298.8
	Үйл ажиллагааны ЦМГ	(6,530.8)	4,683.0
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	-	(4,683.0)
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	(6,530.8)	0.0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	6,530.8	0.0
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	-	-
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	389,669.9	595,445.9
	Урсгал зардал	389,669.9	595,445.9
	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	-
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	389,669.9	595,445.9
	Улсын төсвөөс санхүүжих	-	-
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	388,727.9	593,935.9
	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	40.0	-
	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	902.0	1,510.0

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитын илрүүлэлт

Аудитаар 93.4 сая төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа¹-г аудитын явцад залруулж, баталгаажуулав.

Залруулсан алдаа

Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

- Мөнгөн гүйлгээний тайланд нэмэлт санхүүжилтийн орлого 25.3 сая төгрөгийг үндсэн дансны орлогоор, орон нутгийн төсвөөс санхүүжих 1.9 сая төгрөгийн улсын төсвийн орлогоор тус тус тайлагнасан.
- Нэмэлт санхүүжилтийн орлого, зардлыг 2.0 сая төгрөгөөр дутуу тайлагнасан
- Мөнгөн гүйлгээний тайланд биет ба биет бус хөрөнгө худалдан авсан 3.9 сая төгрөгийг зөрүүтэй тайлагнасан
- Үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгө 60.3 сая төгрөгийг төсвийн хөрөнгөөр худалдан авснаар зөрүүтэй тайлагнасан зэрэг нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" заалтыг зөрчсөн байна.

Залруулагдаагүй нийт 9.5 сая төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс их байгаа тул "Хязгаарлалттай" дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 9.5 сая төгрөгийн 4 зөрчил² илэрснээс, 3 зөрчлийг арилгах албан шаардлага, 1 заалт зөвлөмжийг хүргүүлсэн.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Засаг даргын нөөц хөрөнгөөс сайн малчдад бэлэг дурсгалд 16.7 сая төгрөг, алтайн брэндийн гарын бэлэг авахад 1.0 сая төгрөг, мөнгөн аяга 0.8 сая төгрөг, оны шилдгүүдийн шагналд 1.3 сая төгрөгийг үр ашиггүй зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" 16 дугаар зүйлийн 16.5.4-т "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", 15.1.5-т "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах"; Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаал хавсралтын 7 дугаар зүйлийн 7.1-т "Төсвийн захирагч нөөц хөрөнгийн санхүүжилтийг зөвхөн зориулалтын дагуу зарцуулна" гэж заасантай нийцэхгүй, иж бүрэн байх, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хуулийн хүрээнд засаг даргын нөөц хөрөнгийг захиран зарцуулах албан шаардлага хүргүүлсэн.

5.1 Албан шаардлага

1. Зардлын эдийн засгийн ангилал зөрчин нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 2.5 сая төгрөгийг цалингийн зардлаас шилжүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" 22 дугаар зүйлийн 22.1-т "Төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнана", Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралт "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар" гэж заасантай нийцэхгүй, ангилал, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах албан шаардлага хүргүүлсэн.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

2. Нийгмийн даатгалын хэлтэст 0.2 сая төгрөгийн цалинг дутуу тайлагнасан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1-т "хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх" гэж заасантай нийцэхгүй, ангилал, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нийгмийн даатгалын хэлтэст дутуу тайлагнасан цалинг нөхөн тайлагнах албан шаардлага хүргүүлсэн.

3. Бараа материал 5.3 сая төгрөгийг шаардахаар зарлагадсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-т "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлнө", 8 дугаар зүйлийн 8.2-т "Энэ хуулийн 4.4-т заасан байгууллага нь Төсвийн тухай хуулийн 26.3-т нийцүүлэн нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана." гэж заасантай нийцэхгүй, ангилал, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийг стандартын дагуу хөтлөх албан шаардлага хүргүүлсэн.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Цалингийн зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Үндсэн үйл ажиллагааны орлогыг 1.5 сая төгрөгөөр тасалсан нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-т "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх;"-тай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Батлагдсан төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг хангаж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2024 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/ сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруул аагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	Тоо		Тоо				Тоо		Тоо			

Шарга сумын Засаг даргын тамгын газар	4	93.4	-	-	4	93.4	4	93.4			
Дүн	4	93.4	-	-	4	93.4	4	93.4			

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Шарга сумын Засаг даргын тамгын газар	4	9.5	-	-	3	8.0	1	1.5	-	-	-	-
Дүн	4	9.5	-	-	3	8.0	1	1.5	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн	-	-	-	-	-	-	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Говь-Алтай аймгийн Соёл, урлагийн газар	1	19.8	-	-	1	19.8	-	-
-Нийт дүн	1	19.8	-	-	1	19.8	-	-

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1				1		
	НИЙТ	1	1				1		